



“Уур амьсгалын өөрчлөлт - Залуусын нүдээр”

Үндэсний чуулга уулзалтын хөтөлбөр

Оршил

Хүүхэд, залуучуудад уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын талаар дуу хоолойгоо хүргэхэд нь туслах, тэднийг олон нийтийн яриа хэлэлцүүлэгт оролцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын скаутын холбоо, Пипл ин Нийд ОУБ хамтран Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Залуучууд, хүүхдүүд уур амьсгалын өөрчлөлт болон цэвэр агаарыг дэмжих нь” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн үр дүнд хүүхэд, залуус, өсвөр үеийнхнийг эерэг, идэвхтэй, уур амьсгал, хүрээлэн буй орчны бодлогын талаар мэдлэгтэй, ирээдүйн өөрчлөлтийг бүтээгч, нийгэмд нөлөөлөгчид болгон хөгжүүлэх юм.

Эвентийн зорилго

Энэхүү гурван өдрийн хүүхэд, залуусын чуулган нь уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэг олгох, дэлхийн дулаарлаас үүдэх гамшгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний шинэ санаачилгуудыг танилцуулах, активист хүүхэд залуусыг нэг дор цуглуулж, манлайлагчдын хамт хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, инновацлаг хэрэгслээр дамжуулан бодлого шийдвэр гаргагчидтай харилцах, тэдэнтэй санал бодлоо солилцож хамтран ажиллахад нь дэмжих зорилготой.

Дэмжигч байгууллагууд:

[Швейцарийн хөгжлийн агентлаг](#)

[НҮБ-ын Хүүхдийн сан](#)

Хамтран зохион байгуулагчид:

[Пипл ин Нийд ОУТББ](#)

[Митчелл Сан](#)

[Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв](#)

Чуулганы холбоос: <https://us02web.zoom.us/j/81689827139>

Meeting ID: 816 8982 7139



Эхний өдөр – “УӨА, агаарын бохирдол бидний нүдээр”

9 сарын 17-ны Баасан гараг, 13:00 цагт эхэлнэ.

Хугацаа Үйл ажиллагаа

5 мин	Нээлт болон хөтөлбөр танилцуулга
6-7 мин	Мэндчилгээ А.Энхбат, Байгаль орчин аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга
6-7 мин	Мэндчилгээ НҮБ-ын Хүүхдийн Сангийн Уур амьсгалын өөрчлөлт, цэвэр агаар хөтөлбөрийн ахлагч С.Алтанцэцэг
3-5 мин	Хүүхэд залууст зориулсан “Агаарын бохирдол ба хүүхдийн эрх” богино видео
25 мин	Тусгай зочны ярилцлага “Бидний үр хүүхэд эрүүл, аюулгүй хүрээлэн буй орчинд амьдарч байгаа юу?” Хөтлөгч: Н.Энхзул, Sustainable Mongol подкастын үүсгэн байгуулагч. Зочин: Г.Нарантуяа, Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын гишүүн
45 мин	Панел ярилцлага Хүүхэд, залуусын “Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлыг бууруулахад инноваци технологийг нэвтрүүлж буй туршлага, цаашдын хэрэгцээ шаардлага” • re-Develop цахим төлөвлөлт, • My breath зан дадлын аппликейшн, • Elvieso цахилгаан хөдөлгүүрт машин хэрэглэгчдэд зориулсан аппликейшн • Yo-Car Ярилцлагын удирдагч: Н.Халиунаа - UNLEASH Hacks зохион байгуулалтын ахлах
45 мин	Панел хэлэлцүүлэг “Уур амьсгалын өөрчлөлт хүүхэд залуусын нүдээр” Орон нутаг, дүүрэгтээ өөрчлөлт хийж буй таван хүүхэд, залуусын түүх хуваалцах ярилцлага
10 мин	Товч дүгнэлт ба хаалт

Хоёрдах өдөр - “УӨА, агаарын бохирдлыг бууруулахад бидний оролцоо”



9 сарын 18-ны Бямба гараг, 10:00 цагт эхэлнэ.

Хугацаа Үйл ажиллагаа

10 мин	Уур амьсгалын өөрчлөлт илтгэл – З.Батжаргал, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн үндэсний зохицуулагч
3-5 мин	“УАӨ ба Хүүхэд, залуусын оролцоо” богино видео- Нандин-Эрдэнэ, хүүхэд залуусын төлөөлөл
25 мин	Тусгай зочны ярилцлага “Уур амьсгалын өөрчлөлт ба ногоон санхүүжилтын боломж” Ярилцлагын хөтлөгч: Г.Ану (Anu Narchu) Зочин: М.Болд, Монголын Ногоон Санхүүгийн Корпорацийн гүйцэтгэх захирал
40 мин	Панел хэлэлцүүлэг – “Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад бидний оролцоо” Байгаль орчныг хамгаалах, Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад идэвхтэй үйл ажиллагааг орон нутагтаа явуулж буй 5 залуу манлайлагчдын танилцуулга, нээлттэй хэлэлцүүлэг
60 мин	Салбарын хуралдаан - “Тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмэр оруулах нь” Салбар хуралдаан 1. Хүүхэд залууст тулгарч буй хүрээлэн буй орчны асуудлууд ба сайжруулах арга замууд Салбар хуралдаан 2. УАӨ, агаарын бохирдлыг шийдвэрлэх, мэдээлэл авах үр дүнтэй арга замууд Салбар хуралдаан 3. Цөлжилттэй хэрхэн тэмцэх вэ? Хэрхэн хувь нэмэр оруулах боломжтой вэ? Салбар хуралдаан 4. Хог хаягдлыг бууруулахад хүүхэд, залуусын оролцоо, шинэлэг шийдлүүд
25 мин	Салбар хуралдаанаас гарсан саналыг нэгтгэн, оролцогчдод танилцуулна. Салбар хуралдааны удирдагчид
5 мин	Хаалт Эвентийн удирдагч:



Гуравдах өдөр - УӨА, агаарын бохирдол виртуал үзэсгэлэн

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвтэй хамтран тэдний хийсэн байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг олон нийтэд ойлгуулах видео, подкастуудыг хөтөлбөрийн дагуу түгээнэ.

9 сарын 19-ны Ням гараг, 13:00 цагт эхэлнэ.

Хугацаа Үйл ажиллагаа

60 мин	“Агаар, агаар мандал” сэдэвт видео хичээл
	Агаарын бохирдлын тухай VR museum
20 мин	Байгалийн виртуал музей